

ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ТЭМЦЛИЙН ТҮҮХ- АМАН ЗОХИОЛЫН ХОЛБОГДОЛ

М. Зэнээ

«Эдүгээ хүртэлх бүх нийгмийн түүх ангийн тэмцлийн түүх»¹ хэмээн марксистууд сургажээ. Эрх чөлөө, тусгаар тогтнолын төлөө ангийн эрх ашгаа хамгаалан дотоод гадаадын дарлагчдын эсрэг явуулсан ард түмний тэмцэл зогсож байгаагүйн зэрэгцээ аман зохиолд байнга тусч иржээ.

Ангит нийгмээс аль эрт бий болсон ардын аман зохиолыг үзэл суртлын зорилгодоо хэрхэн ашиглаж ирснээр нь дарлагч ангийн эрх ашгийг хамгаалсан харгис чиглэл, дарлагдагч ангийн үзэл санаа, хүсэл мөрөөдлийг тусгасан ардач чиглэл гэж хоёр хуваан үздэг² юм.

Энэ өгүүлэлд монголын нийгмийн хөдөлгөгч хүч болсон малчин ардын үзэл санаа, хүсэл мөрөөдлийг тусгасан эрх чөлөөний тэмцлийн сэдэвтэй аман зохиолыг түүхэн үүднээс тодруулахад гол анхаарав. Урьд өмнө Монголын ард түмний эрх чөлөөний тэмцлийг түүхэн баримтаар судалсан бүтээл олон гарсан боловч ардын аман зохиолтой холбон тусгайлан судалсан нь үгүй билээ.

Ард түмний түүхийг зөв бичье гэвэл түүхэн сурвалж ашиглахаас гадна түүхэн үйл явдал, түүхт хүмүүсийн тухай ард түмний зохиосон домог яриа, тууль, түүхэн дууг сайн мэдэх хэрэгтэй. Ардын аман зохиолыг сайн мэдэх нь «тухайн үеийн бичгийн хүмүүс ба ноёд язгууртны бичиж үлдээсэн бичиг материалаас зарим талаар нэн ч үнэ цэнэтэй байж болох»³ юм. Энэ ч учраас миний бие 1981 онд «Өвөр Монголын ардын аман зохиол». 1987 онд «Эрх чөлөөний тэмцэл аман зохиолд» гэсэн хоёр ном бэлтгэж хэвлүүлсэн билээ. Ийм бүтээл бичиж хэвлүүлэхэд ШУА-ийн сурвалжлагч гишүүн, доктор П. Хорлоогийн «Монгол ардын дууны яруу найраг», Хэл зохиолын хүрээлэнгийн аман зохиолын зарим цуврал болон түүх-аман зохиол судлалаар Б. Я.Владимирцов, Г. Н. Потанин, А. Позднеев, И. Я. Златкин, нэрт академич Б. Ренчин, Ц. Дамдинсүрэн, Ш. Нацагдорж, доктор Н. Ишжамц, Ш. Сандаг нарын олон судлаачдын бүтээл тулгуур материал болсныг талархан тэмдэглэхийг хүсч байна.

Эрх чөлөөний сэдэвтэй аман зохиолыг тодруулан авч үзэхийн тулд монголчуудаас гадаадын түрэмгийллийн эсрэг явуулсан тэмцлийн түүхийг дараахь байдлаар үечилж болно гэж үзэж байна. Энэ үе болгон тухайн бодит байдлаа тусгасан аман зохиолттой байлаа.

1. МЭӨ VII—I зууны үе. Энэ үед монголын ард түмэн эрх чөлөө, тусгаар тогтнолоо бүрэн бүтэн хадгалж, гадаадын элдэв түрэмгийлэх аргын эсрэг шийдвэртэй тэмцэл явуулж байжээ. Үүнийг илчилсэн ардын аман зохиол ч цөөнгүй байна. Тухайлбал энэ үетэй холбогдох «Цагаан хэрэм»⁴ гэж дуу бий. Цагаан хэрэм бол МЭӨ VII--Ш зуунд баригдсан нүүдэлчин монгол, суурьшмал хятад хоёр улсын хэн ч өөрчлөн зөөж чадахгүй **Улсын хил** билээ. Гэтэл энэ бодит түүх гуйвуулагдах явдал цөөнгүй гарч байв»...Их хэрэм нь МЭӨ IV зуунд холбогдсон. Гэвч тэр үед ч Их хэрэм нь Хятадын хил байгаагүй юм»⁵ гэж хэвлэлд бичсэн байдаг. Үүнтэй холбогдуулж түүхийн нэгэн барим-

тыг сөхвөл МЭӨ 162 онд Хятадын Хан улсын хаан Сяо Вэньди Хүннүгийн хаан Шаньюйд илгээсэн захидалдаа «Цагаан хэрмээс хойшхи нум агсагчдын улс нь Шаньюйн зарлигийг дагаж, Цагаан хэрмээс урагших түшмэдийн дээл, малгай өмсөгчдийн улс нь харин надад захирагдана. Хан улс, Хүннү хоёр бол мөр зэрэгцэх хүчирхэг улсууд юм»⁶ гэж бодит түүхийг хүлээн зөвшөөрч байжээ. Хоёр улсын хил Цагаан хэрэм байсныг түүхийн бүх материал хөдөлгөөнгүй батлаад зогсохгүй өмнө өгүүлсэн «Цагаан хэрэм» хэмээх дууны 5 бадаг хөдөл бөргүй нотолдог. Уг дууны:

«...Чийрэг Монголоос болгоомжилж

Цагаан хэрэмийг байгуулав» гэсэн хоёр мөр аль ч улсад эрх чөлөө, тусгаар тогтнолын тэмцэл аман зохиолтой нягт холбоотой байдгийг тодорхой харуулсан үнэмшилтэй баримт болж чадаж байна. Энэ үеийн аман зохиолын болоод бодит түүхийн бас нэг тодорхой жишээ бол Хан улсын хаанаас Хүннүгийн хаанд өгсөн Ван Жаознь хатан⁷ юм. Энэ хатны тухай домог, яриа түүхийн сурвалж материал монгол ба хятадад цөөнгүй байдаг.

2. МЭ I зуунаас XII зууны үе. Монголчууд эрх чөлөө, тусгаар тогтнолынхоо төлөө харийн түрэмгийллийн эсрэг мохолгүй тэмцсэн түүхийн хатуу ширүүн үе байлаа. Энэ үеийн бодит түүхийг тусгасан ардын домог, бэлэг сургаалууд олон байдаг. Персийн түүхч Рашит Ад-Дини «Судрын чуулган-д тэмдэглэн үлдээсэн «Эдгүнэ хунгийн домог»⁸ эрх чөлөө, тусгаар тогтнолын төлөө монголчуудын тэмцэл очоос дөл болон ассаны үлгэр мөн. Энэ үеийн бас нэг жишээ бол түүх-уран зохиолын гайхамшигт дурсгал «Монголын нууц товчоо»-нд үлдэж хоцорсон аман зохиолын дурсгалууд,⁹ өдий төдий домог, үлгэр, зүйр цэцэн үгс болно.

3. XIII-- XVII зууны үе. Энэ үед Монгол нутаг дээр аймаг, омгийн задрал хүчтэй болж. тал нутгийн феодалуудын хоорондын тэмцэл ширүүсч, Алтан улс буюу Хойд хятадаас монголчуудын эсрэг 3 жил тутамд явуулж байсан эрчүүдийг нь хүйс тэмтрэх,¹⁰ эв эвдэн тангараг таслах бодлогыг ялан давж «Нэгдсэн Монгол улсыг байгуулан» Чингис хаан хийгээд түүний үе залгамжлагчид төр төвшитгөн тогтоосон цаг. Гэвч булаан эзлэх түрэмгий дайн, буталган сарнихаар харийн бодлогоос болж Монгол гүрний хүч тарамдаж, бусдын түрэмгийлэлд өртөх үүд хаалга нээгдсэн үе байв. Энэ үеийн аман зохиолын дурсгалд «Гурван зуун тайчуудыг дарсан домог», «Аргусун хуурчийн домог», «Өнчин хөвгүүний цэцэлсэн шаштир», «Чингисийн эр хоёр загалын тууж», «Мандухай цэцэн хатны домог»¹¹ гээд утга санаа, гүн ухааны хувьд харьцангуй давшсан түүхэн сэдэвтэй аман зохиолууд гарч бичиг зохиолд тэмдэглэгдэн тухайн цаг үеийн түүхээ тодруулан хойч үедээ үлджээ.

4. XVII- XX зууны эхэн үе. Энэ үед дотоодод феодалын бутрал хүчтэй явагдаж, гадаадын түрэмгийллийн эсрэг монголчуудын явуулсан эрх чөлөө тусгаар тогтнолын төлөө тэмцэл улам идэвхжиж байсан боловч хятад, манжийн хагалан бутаргах төрийн бодлогоос болж нийт монгол үндэстэн Манж Чин улсын харьяанд гурав таслагдан орсон түүхийн хамгийн гутамшигтай үе байлаа. Энэ үед дотоодын феодал, гадаадын манж нарын эсрэг монголчууд хамгийн өргөн фронтоор тэмцэж байсан учир тэр бүр нь ардын аман зохиолд их хэмжээ гээр тусч үлджээ. Ойрадын Галдан бошгит, Амарсанаа, Хотгойдын Чингүнжав, Зүүн Монголын Гүнсанаа нартай холбогдох түүхэн аман зохиол ардын дунд олон хувилбараар тархаж, өнөөг хүртэл хадгалагдан бидэнд үлдсэн байна.

5. XX зууны эхнээс хойшхи үе. Энэ үед Монгол дахь эрх чөлөө, тусгаар тогтнолын олон үеийн тэмцэл ялалтад хүрч монгол үндэстэн Азийн элгэн дээр нойрноос сэржээ. Энэ үеийн аман зохиол монголчуудын олон үеийн эрх чөлөөний тэмцлийг магтан дуулж, нэгэнт олж авсан хувьсгалт ололтыг бататган, залуу үеэ эх оронч, хувьсгалч баатарлаг уламжлалаар хүмүүжүүлэхэд чиглэх болсон болохоор «түүхийн алтан үе» гэж зүй ёсоор нэрлэж болно. Эл үеийн аман зохиолд харийн түрэмгийллийн эсрэг «Гамин цэрэг», «Бундан дэнлүү» зэрэг олон дуу, шог хошин яриа болон «Шивээ хиагт», «Магнаг үсэгтэй туг», «Дотоод Монголыг мандуулах дуу» гээд хувьсгалт олон дуу орно. Мөн үед Япон болон Гоминьданы хятадын түрэмгийллийг эсэргүүцсэн олон дуу Өвөр Монголд зохиогдон гарч байв.

Монгол улс Төв Азид мандаж, буурч байсан бүх л үед гол харил цаатай байсан улс нь Хятад, Манж, Орос, Төвд, Азийн бусад орнууд байлаа. Эднээс Монголын талаар хамгийн их анхаарлыг Хятад, Манж зэрэг улсууд тавьж байв. Тэд монголыг аль болохоор нэгтгэхгүй байх, дотор нь бужигнуулж байх чиглэл баримталж ар, өвөр, баруун, зүүн гэх мэтээр хуваан эцэстээ Хаант Орос, Хятад хоёр үгсэн хуйвалдаж¹², Өвөр Монголыг салгасан билээ. Ар, Өвөр Монголыг «нөлөөнийхөө хүрээнд» тасчин хуваасан Япон, Хаант Орос хоёрын 1907, 1910, 1912, 1916 оны империалист нууц хэлэлцээр нь Өвөр Монголыг Хиагтын 3 улсын гэрээ¹³ гэгчээр салган авах үндэс болжээ. Дашрамд Хятадаас Монголыг мэдэлдээ оруулахын тулд дээр үеэс хэрэглэж ирсэн «Зими» буюу «Бэлэгдэн хазаартах», «үэр» буюу «таван урхи» зэргийг монголчууд бид сайн мэдэж байх хэрэгтэй. «**Нүдийг** урвуулахын тулд хээнцэр хувцас, тэрэг өгөх, **дурьг** урвуулахын тулд сайхан хооллох, сонорыг урвуулахын тулд хөгжим эхнэр өгөх, **хүслийг** урвуулахын тулд байр сууц, татвар эмс өгөх, **ухааныг** урвуулахын тулд дарс, хоолоор дайлах хэрэгтэй»¹⁴ гэсэн дипломат бодлого явуулдаг байжээ.

Монголын эрх чөлөө, тусгаар тогтнолын эсрэг харийн түрэмгийлэл энэ мэт ямар ямар аргаар явагдаж байсныг түүх-аман зохиолын харилцан холбогдол дээр хөндөж, түүний эсрэг ард түмэн хэрхэн тэмцэж ирсэн, тэр тэмцэл нь ардын аман зохиолд хэрхэн тусч байсныг товч тэмдэглэх нь зүйтэй юм.

Монголыг эрхшээлдээ оруулах харь бодлого

1. Өнгөөр татах; 2. Мөнгөөр урвуулах; 3. Хүчээр нухчих; 4. Эдийн засгаар хавчих; 5. Газар нутгийг хэрэглэх; 6. Шашинаар мунхруулах; 7. Хүйсээр уусгах; 8. Дотроос нь задлах; 9. Ёс суртахуунаар доройтуулах зэрэг үндсэн 9 аргаар илэрч байлаа.

1. Өнгөөр татах аргыг МЭӨ I зуунд хэрэглэгдэж байсныг Ван Жаозюнь хатны үйл явдал бүрэн гэрчилнэ.¹⁵ Манж нар эл аргыг өвлөн авч Энх-Амгалан хаан өөрийн 7 гүнжийн 1-ийг халхын Дондовдоржид, үлдсэн 6-г нь Өвөр Монголын ноёдод хатан болгон өгчээ.¹⁶ Засагт хаан Цэвээнжав, Түшээт хааны засаг Цэрэн, түүний дүү Гунгааравдан, 3-р үеийн Лхаваандорж, 7-р үеийн Наянт нар цөм эфу буюу тавнан болжээ. Ийм бодлогыг илчилсэн аман зохиолын жишээ цөөнгүй бий.¹⁷

2. Эд мөнгө, хэргэм зэргээр том толгой феодалуудыг татах бодлого мөн эртний уламжлалтай. Үүнд татагдсан Хорчины Ууба тайж, Түшээт хан Чихундорж, Сайн ноён хан аймгийн Эфү Цэрэн түүний 7 удмын ноёдыг нэрлэж болно. Монголчууд ийм явдлыг жигшиж «Ноён урваач, нохой шарваач» гэдэг зүйр үг хэлэлцэх болсон ба «Даадай тэрэг», «Уртын сайхан хүрэн» зэрэг олон дуунд ийм байдлыг тусган үлдээсэн байдаг.

3. Цэрэг зэвсгийн хүчээр Монголын ард түмний эрх чөлөө, тусгаар тогтнолыг нухчин дарах харийн оролдлого зогсож байсангүй. 1372 оны түрэмгийлэл,¹⁸ 1696 онд Галдан бошгитын эсрэг хийсэн тулалдаан.¹⁹ 1755—1758 оны Монголын эрх чөлөө, тусгаар тогтнолын эсрэг зэвсэгт түрэмгийлэл,²⁰ 1912—1915, 1919 оны Хятадын хар цэргийн түрэмгийлэл²¹ зэрэг олон үйл явдал үүнд холбогдолтой. Ийм түрэмгийллийн эсрэг баатарлаг тэмцэл явуулж байсан Галдан бошгит, Амарсанаа, Чингүнжав. Шуну баатар, Гүнсаваа, Манлай ван Дамдинсүрэн, Хатанбаатар Магсаржав нарын тухай домог, дуу Монголд маш олон бий.

4. Эдийн засгийн хувьд эрхшээлдээ оруулах бодлого эзлэн түрэмгийлэх бүх санаархлын үндсийн үндэс байлаа. Монголын нийслэл Их Хүрээ, Улиастай, Ховдын хязгаарт байсан олон тооны пүүс ард түмнийг шулан мөлжих хамгийн харгис үүргийг гүйцэтгэж байв. Өвөр Монголын Чуулалт хаалга хотод хятад пүүс 1721 онд 80 байсан бол 1820 онд 230 болжээ.²² Энэ үеийн бас нэг хүнд дарамт бол өртөөний алба байв. Манжаас Ар Монголд 120 суурь өртөө ажиллуулж жилд хагас сая толгой мал идэж сүйтгэж байлаа.²³ Ер нь Хятад, Манжаас эдийн засгийн хувьд явуулсан бодлого Монголын гол баялаг мал аж ахуйд хамгийн их гарз учруулжээ. Үүнтэй холбогдох аман зохиол арвин их байдаг.²⁴

5. Газар нутгийг хэсэглэн салгах бодлого он удаан жил тасралтгүй явж иржээ. «Хөршийн нутгаас алга дарга хэмжээгээр аван авсаар дуусгах», «хоёр сөөм урагшилж, нэг сөөм ухрах» зэрэг олон арга хэрэглэх замаар Монголын нутгаас таслан авах явдал олон зуун жил үргэлжилсэн билээ. Бэлчээр нутгийг хэсэглэн авч колоничлох бодлогыг эсэргүүцэн Жирэмийн чуулгын Тогтох тайж 1901 оноос тэмцсэн бол Хорчины Гаадаа мээрэн 1929 оноос бослого гаргажээ.²⁵ Энэ хоёр хүний тухай олон хувилбартай хэдэн арван бадаг дуу өнөөдрийг хүртэл ард түмний дотор дуулагдсаар байна.

6. Шашинаар мунхруулах арга Хятад, Манжаас Монголын хувьд явуулсан бодлогод зохих байр эзэлж иржээ. Монгол нутаг дээр олон зуун сүм дуган байгуулан, эрчүүдийг нь тэмцэх чадваргүй болгож хүрээ хийдэд шавилан суулгах замаар «Монголыг буутай цэргээр мануулснаас, гуутай бурханаар мануулбал илүү ашигтай» гэх улс төрийн бодлого явуулж ард олныг мухар сүсэгт²⁶ мунхруулан барьж байв. Шашиныг эсэргүүцсэн олон тооны зүйр цэцэн үг, шог хошин яриа ардын домог үлгэр аман зохиолд бий болж өнөөг хүртэл яригдсаар л байна.

7. Хүйсээр уусгах бодлого бол «цусгүй колоничлох» арга бөгөөд хэрэгжүүлэхийн тулд иргэнийг үржүүлж, захыг бататгах засгийн арга»²⁷ гэгчийг явуулж «Хөрсөнд нь тариа цацаж, хүйсэнд нь үр цацах»²⁸ ажил хийж байсныг ард олон эрс эсэргүүцэж олон тооны зүйр цэцэн үг, ардын дуу зохион тэмцлээ илэрхийлж байлаа.

8. Дотроос нь задлах арга бол Хятад, Манжаас Монголын хувьд явуулж байсан хамгийн ноцтой арга байлаа.

Монгол орон феодалын бутарлын улмаас ар, өвөр, баруун, зүүн хэмээн хуваагдаж, тэднийг бие биеийн эсрэг яс хаян тэмцэлдүүлж хүчийг сарниулах нарийн аргыг бусад зарим улс гүнзгийрүүлж байсныг «и и жи и» буюу «и и фа жи» гэж түүхэнд тэмдэглэдэг. «Нэг бүдүүлгийн гарт могой бариулж, нөгөө бүдүүлгийг захирах» буюу «Харь угсаатныг турхиран, өөрсдийг нь довтлох» гэгч эл аргыг МЭӨ 200—154 онд Хятадын Вэньди хааны түшмэл Чао Цо боловсруулсан²⁹ гэж үздэг. Манж нар эл аргыг хэрэглэж 1636 онд Өвөр Монголыг, 1691 онд Ар Монголыг, 1758 онд Баруун Монголыг тус тус эрхшээлдээ оруулан

колониалчлосон билээ. Энэ үетэй холбогдох ардын аман зохиол Монголын ард түмний дотор хамгийн арвин бий.

9. Ёс суртахуун, бэлгэ чанарын хувьд мохоож доройтуулах арга бол нэг ёсны үзэл суртлын арга юм. Эл бодлогыг Монголын ард түмэн онцгой сайн ойлгож, эрс няцааж иржээ. «Жигүүртний хаан Хангарди», «Эр зоригийн таван омог», «Хар хүрээтэй малгай», Гаанс хөөрөгний домог³⁰ зэрэг олон тооны домог, хууч ярианаас эл аргыг тодорхой ойлгож болно.

Өмнө товч хөндсөн Монголчуудын эрх чөлөө, тусгаар тогтнолын тэмцэл, тэр тэмцэлтэй холбогдох ардын аман зохиол, харийн түрэмгийллийн арга хэлбэр зэргээс үндэслэн Монгол үндэстэн үүсэн бүрэлдсэн цагаасаа эрх чөлөө, тусгаар тогтнолоо онцгой эрхэмлэж, тэр нь ардын аман зохиолд ямагт тусгалаа олж ирсэн байна гэсэн үндсэн дүгнэлт хийж болно. Ингэхээр ардын аман зохиол аливаа үндэстний хойч үеэ эх оронч үзлээр хүмүүжүүлэх гол арга болж ирсэн нь тодорхой ажээ. Ардын аман зохиолын энэ их хүч чадлыг онцгой анхаарч аман зохиол бол «...хүч чадал, эрх чөлөөнд гүн итгүүлж, эх орноо хамгаалах, хайрлах, эрэлхэг их чадал, тэнхээндээ итгэх сэтгэлийг төрүүлдэг юм»³¹ гэж мэргэдүүд үзсэн нь бодит түүхийг тусгаж, эх орон, эрх чөлөөг эрхэмлэсэн ардчилсан, дэвшилттэй аман зохиолыг нарийн ч судлан ирээдүй хойч үедээ үлдээхийн учир холбогдлыг үнэлсэн өндөр үнэлэлт ажээ. Энэхүү үнэлэлтийг удирдлага болгон эл өгүүллийг уншигч та бүхэндээ өргөн барьж байна.

¹ К. Маркс, Ф. Энгельс, Эв хамт намын тунхаг. УБ., 1947, 42-р тал

² В.И. Ленин. зохиолууд. 20-р боть, 8-9-р талыг үзнэ үү

³ Монгол хэл, утга зохиол сэтгүүл. Хөх хот. , 1982, No 2 104-р тал

⁴ «Монгол ардын дууны түүвэр Хөх хот. 1949

⁵ Информационный бюллетень агентства Синьхуа». , Пекин., 1969, X.9., No3305. , 3 -6 р тал

⁶ «Маоизм маогийнхан» УБ., 1975. П дэвтэр 26—27-р тал

⁷ М.Зэнээ. «Эрх чөлөөний тэмцэл аман зохиолд» УБ., 1987 номд тодорхой бий.

⁸ Г. Буянбат. «Монголын уран зохиолын шилдэг өв уламжлал» Хайлаар. , 1983, 3-р тал

⁹ Г. Буянбат. «Монголын эртний бэлэг сургаал». , Хөх хот. , 1985, номд энэ талаар тодорхой өгүүлжээ.

¹⁰ «Өвөр Монголын Нийгмийн Шинжлэх ухаан» сэтгүүл Зуу-уд. 1982. No 1. 12-р тал

¹¹ Монгол уран зохиолын түүх. Хөх хот., 1984, 245—308-р тал –

¹² Э. Д. Гримм , Сборник договоров и других документов по истории международных отношений на Дальнем Востоке. (1842—1925) М., 1927.

¹³ Ш. Сандаг. Монголын улс төрийн гадаад харилцаа (1850—1919) УБ., 1971, II-р тал

¹⁴ Г. Сүхбаатар, Монголчуудын эртний өвөг. УБ., 1980, 97-р тал

¹⁵ М. Зэнээ. «Эрх чөлөөний тэмцэл аман зохиолд» УБ., 1987 , номд тодорхой байгаа тул үзнэ үү.

¹⁶ Ц. Дамдинсүрэн. «Гүнжийн сүм» УБ., 1961, 20-р тал

¹⁷ М. Зэнээ, «Эрх чөлөөний тэмцэл аман зохиолд» номоос тодорхой жишээнүүдийг үзнэ үү.

¹⁸ «Дорнодахины судлалын асуудал» УБ., 1978. No 1, 97-р тал

¹⁹ «Энх-Амгалан хааны бодлогын бичиг 25-р дэвтэр

²⁰ Н. Ишжамц, Монголын ард түмний 1755—1758 оны тусгаар тогтнолын зэвсэгт тэмцэл. УБ., 1962

²¹ Дорнодахины судлалын асуудал. УБ., 1980. No3. 148-р тал

²² Ш. Таяама, «Чин улсын үеийн Монголын нийгмийн байгуулал» Токио. 1954. ,280-р тал,

²³ Н. Ишжамц. Дурдсан зохиол. 49-р тал

²⁴ М. Зэнээ. Дурдсан зохиол, УБ, 1987 номоос үзнэ үү

²⁵ М. Зэнээ. «Өвөр Монголын ардын аман зохиол». УБ., 1981. номоос үзнэ үү

²⁶ «Өвөр Монголын нийгмийн шинжлэх ухаан, Зуу-Уд. 1984, No 1, 172-р тал

²⁷ Ш. Сандаг «Монголын улс төрийн гадаад харилцаа». (1850—1919) УБ., 1971

²⁸ М. Зэнээ, Дурдсан зохиол. УБ., 1987 номд тодорхой бий.

²⁹ Г. Сүхбаатар. «Монголчуудын эртний өвөг». УБ., 1980. , 97-р тал

³⁰ М Зэнээ. Дурдсан зохиол. УБ., 1987., номоос үзнэ үү.

³¹ К. Маркс, Ф. Энгельс. Об искусстве» т. П. 1957, 559-р тал

МАНЖИЙН ҮЕИЙН МОНГОЛЫН НОЁДЫН ЗЭРЭГ ХЭРГЭМ

А. Дашдэмбэрэл

Манжид эзлэгдэхийн өмнө халхын ноёд үйзэн өлзийт, мэргэн, цэцэн, далай, дайчин, илдэн хошууч, хөндлөн бошогт, цэцэн жонон, түшээт, эрх тайж, дархан хунтайж зэрэг цолтой байсны гадна хятад гаралтай ван, гүн, тайж гэх мэтийн хэргэм цол нэлээд дээр үед ч байсан бололтой.

Монголын түүх, сурвалж зохиолуудаас үзэхэд монгол аймгууд анхны төр улсаа байгуулан феодалын түрүү үеийн хөгжилтэй үедээ бусад аймаг улсуудын эсрэг дайн байлдаа хийдэг байжээ. Хөрш зэргэлдээ орших эртний соёлтой хятад улсруу байнга уулгалан довтолдог байсан учраас хятадын хаад монгол аймаг улсуудтай эвтэй найртай байхын тулд их хэмжээний бэлэг сэлт барьж, хэлэлцээр байгуулан хамгийн хүндтэй цол хэргэмээ шагнасан олгодог байв.

Монголын анхны төр улс Хүннү-гийн хаан Модун шаньюй улсаа гурван хэсэгт хувааж төвийн хэсгийг өөрөө захирч, зүүн баруун этгээдийг жуки ван, лули ван нарт захируулдаг байжээ¹.

147— 167 оны үед Хятадын Хан улсын хаан Сяньбийн толгойлогч Таньшихуайд ван хэргэм шагнаж, найрамдал байгуулахыг оролдож байсны гадна түүний хүү Кэбинынд Вэй улсын ван хэргэм шагнаж байв.² Мөн нирун (жужан) улсын үед ч ван хэргэмтэй ноён хэд хэд байсан мэдээ бий. Харин Түрэг, Уйгар, Киргис, Киданы үед ван цолтой ноёд байсан мэдээ ховор байна.

Хамаг Монголын ханлигуудын үед 1194 онд Алтан улсын Вангин Чинсан Татарын Мэгүжин сүүлтийг үг даахгүй боллоо хэмээн цаанаас цэрэглэж, Чингис хаан бас татаруудаас эцэг, өвгөдийнхөө өсийг авах гэж хэрэйдийн хаан Тоорилтой наанаас цэрэглэж Мэгүжин сүүлтийг алав. Вангин Чинсан үүнд ихэд баярлаж, Чингис хаанд «Чаутхури» гэдэг цол, Тоорилд ван цол өгчээ. Үүнээс эхлэн хэрэйдийн хан Тоорилыг ван цолтой хамтруулан Ван хан гэх болсноос хойш Тоорил нь ван хан гэж алдаршжээ³. Тэр үед монгол аймгуудын дотор хэрэйдийн Тоорилоос өөр ван цолтой хүн байгаагүй юм. Энэ ван цол нь Зүрчидийн Алтан улсаас олгосон болой.

Монголын нэгдсэн төрийг байгуулсны дараа улаагчин үхэр жил (1217) Чингис хаан Сартуулыг биеэр дайлах болж, жин юан буюу Алтан улсыг дайлах хэргийг Мухулайд тусгайлан тушаав. Тэр жилийнхээ намар нь зарлигаар дэлхий дахины цэргийн их өрлөг мужуудыг ерөнхийлөн захирсан тайш, улсын ван (го ван)-гийн хэргэм зэрэг өгч